


2011-05-10

## ЦӨМИЙН бизнесийг МОНГОЛД хэн хийж байна вэ???



Өнгөрсөн оны 11 сарын 19-нд Өнөөдөр сонинд нэгэн товчхон мэдээ гарсныг хүмүүс тэр бүр анзааралгүй өнгөрчээ. Чухамдаа зэрвэсхэн харвал анхаарал татаад байхаар ч мэдээлэл биш юмсанж. Тус мэдээний дор ганцхан сэтгэгдэл үлдээсэн байдал ч үүнийг гэрчилнэ.

Мэдээг бүрэн эхээр нь та бүхэнд толилуулбал:

## **“Toshiba” Монголын компанитай хамтран ажиллана**

2010-11-24

*“Toshiba” Монголын “MNFCC” компанитай газрын ховор элементийг боловсруулах, дэд бүтцийг хөгжүүлэхэд хамтран ажиллахаар харилцан ойлголцлын Санамж бичигт өнгөрсөн баасан гаригт гарын үсэг зуржээ. Ингэснээр тэд уран болон газрын ховор элементийг боловсруулж, дэд бүтцийг хөгжүүлэхэд шаардлагатай бүх ажлыг хамтран гүйцэтгэхээ баталж буй аж.*

*Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг дэмжихээр дулааны, цөмийн, нарны эрчим хүчний тогтолцоог сайжруулахад туслахаа амлаад, түүнд шаардагдах газрын ховор элементийн тогтвортой нийлүүлэлтийг хангахын тулд боловсруулах тал дээр ч хамтран ажиллана хэмээснийг [www.asahi.com](http://www.asahi.com) цахим хуудсанд тэмдэглэжээ.*

Б.ЦЭЦЭГ <http://www.mongolnews.mn/i/13377>

Дор нь “Энэ MNFCC гэж хэний компани билээ” гэж асуусан ганц сэтгэгдэл үлджээ....

**TOSHIBA**  
Leading Innovation >>>

Харин энэ талаар Тошиба корпорацийн цахим хуудсанд олон нийтэд зориулсан арай дэлгэрэнгүй мэдээлэл байсныг орчуулан тавьбал:

***Тошиба компани Монголын МНФСС компанитай ашигт малтмал, нийгмийн дэд бүтцийг хөгжүүлэх талаар харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зуржээ.***

2010 оны 11 сарын 26

*ТОКИО ---Toshiba корпораци нь Монголын MNFCC компанитай Харилцан Ойлголцлын Санамж бичигт гарын үсэг зурж, цаашид Монголын ашигт малтмалыг, үүнд уран, газрын үнэт металл зэргийг боловсруулах, хөдөөгийн дэд бүтцийг сайжруулах тал дээр хамтран ажиллах юм байна.*

*Японы Ерөнхий Сайд Наото Кан нь Монголын Ерөнхийлөгч Ц. Элбэгдоржтой 2010 оны 11 сарын 19-нд уулзаж, стратегийн түншлэлийг өргөжүүлж, Монголын ашигт малтмалыг боловсруулах асуудлаар харилцан ашигтай ажиллахаар зөвшилцжээ. Цаашид хоёр орны эдийн засгийн харилцааг өргөжүүлэхээр ажиллана.*

*Ийнхүү Санамж бичигт гарын үсэг зурснаар Toshiba корпораци нь MNFCC компанитай харилцан ашигтай хамтын ажиллагааг өрнүүлэх юм. MNFCC компани нь Монголын төрийн ба хувийн өмчийн түншлэл хөтөлбөрийн дагуу*

*ашигт малтмал, эрчим хүч, нийгмийн дэд бүтцийн салбарт стратеги зөвлөгөө өгч, бодлогыг хэрэгжүүлэх үүрэгтэй юм байна. Тошиба корпорациас Монгол улсын дулааны, цөмийн болон нарны фотовольт эрчим хүчний системүүд болон тэдгээрийн дамжуулах болон түгээх сүлжээ зэрэг эдийн засгийн хөгжлийг баталгаажуулахад чухал үүрэг бүхий гол гол нийгмийн дэд бүтцийн байгууламжуудын боломж бололцоог судалж, тэдгээрийн хангамж нийлүүлэлтийг тогтворжуулахын тулд ашигт малтмалыг боловсруулах асуудлаар хамтран ажиллахаар болжээ.*

***MNFCC ХХК тухай мэдээлэл***

***Компаний нэр:*** MNFCC компани

***Байгуулсан огноо:*** 2010 оны 9 сар


***Төлөөлөгч:*** Дүгэрсүрэнгийн Дашдорж

***Үйл ажиллагааны чиглэл:*** Ашигт малтмал, эрчим хүч болон нийгмийн дэд бүтцийг хөгжүүлэх Монголын төр ба хувийн салбарын түншлэл

[http://www.toshiba.co.jp/about/press/2010\\_11/pr2601.htm](http://www.toshiba.co.jp/about/press/2010_11/pr2601.htm)

Эндээс үзвэл хэд хэдэн дүгнэлт хийж болох юм:

**Нэгдүгээрт,** Дүгэрсүрэнгийн Дашдорж гэдэг хүний 2010 оны 9 сард байгуулсан MNFCC гэдэг компани нь 2 сарын дараа Монголын төрийг төлөөлөн Тошибатай гэрээ хийжээ. Тэрээр **Ерөнхийлөгч хүртэл ард нь байдаг зайтай эр** болж таарлаа.



**Хоёрдугаарт**, судлаач Д. Ганхуяг гуайн бичээд байсан өнөө алт эрдэнэсээс ч үнэтэй ховор элемент агуулсан газрын ховор металлаа (ГХМ) Японд наймаалцахаар шийджээ. Үнэндээ тэр ГХМ гэгчийг богино долгионы зуух, телевиз, камерийн линз, компьютерийн ой санамж зэрэг цахилгаан бараа бүтээгдэхүүний эд анги, мөн лазер, цөмийн зай батареи, рентген машин бүтээхэд ашигладаг. Япон бол ГХМ-ийн асар том хэрэглэгч, тэгээд бас өөрсдөө ГХМ-ын нөөцгүй тул Хятадаас хараат байдаг гэхээр асуудал ойлгомжтой.

<http://gankhuyag.wordpress.com/2011/03/09/hkldwyg/>

<http://golomt.org/2011/03/18/ghm2/>

**Гуравдугаарт**, Дүгэрсүрэнгийн Дашдорж гэдэг залуу нь **Гадаад Хэргийн Яамны Тусгай үүрэг гүйцэтгэгч элчин сайд А. Ундраагийн нөхөр** нь юм байна. Тэд хоёулаа МУИС төгсөөд, АНУ-д цөмийн физикийн чиглэлээр докторын зэрэг хамгаалсан ажээ. АНУ-д ажиллаж амьдрах эрхээ авсан залуу хос чухам ямар учраас Америк дахь тогтсон амьдралаа, Станфордын зочин профессорын хүндтэй албаа орхиод Монголд ирсэнийг олон хүн гайхаж байсан нь саяхан.



Бодоод үзвэл “MNFCC” ХХК гэдэг нь гэр бүлийн гэхээсээ бараг **дээдсийн хүрээнийхний нууцхан бизнес бололтой**. Тухайлбал, Ерөнхийлөгч Ц. Элбэгдорж эхний суурийг тавиад ирсэн бол Гадаад Харилцааны сайд Г.Занданшатар Японд болсон айлчлалын тухай 2011 оны 11 сарын 22-нд мэдээлэлдээ энэ удаагийн айлчлал төлөвлөсний дагуу явж, **“шийдэх асуудлаа бүгдийг нь шийдсэн”** гээд **хоёр улсын харилцаанд шинэ хуудас, шинэ үе нээгдэж байна** гэж байжээ.

<http://news.gogo.mn/r/79415>



Цааш нь адал явдал бүр улам сонирхолтой болж байх юм. Монголчууд бид Тошибаг электрон бараа хийдэг гэдгээр нь мэддэг. Харин Тошиба корпораци нь **Япондоо хамгийн олон цөмийн реактор барьж нийлүүлдэг компани** гэдгийг та сонссон уу? Тэгвэл, Фукушима-Даичи дахь 6 реакторын 4-ийг нь Тошиба корпораци барьсан юм байна. Ингэж бодвол дээрх мэдээнд зэрвэс дурдагдсан ураны асуудал нилээдгүй чухал бололтой. Нөгөөтэйгүүр, Японд гамшиг тохиолдсоны дараахан А. Ундраа Японы атомын реактор баталгаатай, унтраах боломжтой, цөмийн цацрагийн аюулгүй гэж ярьж байсан билээ.

<http://www.bloomberg.com/news/2011-03-31/downfall-of-tepco-may-hurt-nuclear-sales-at-toshiba-hitachi.html>

[http://gunuhaanduguilan.blogspot.com/2011/05/blog-post\\_7567.html](http://gunuhaanduguilan.blogspot.com/2011/05/blog-post_7567.html)

Бид Япончуудад уран, ГХМ зэргээ өгч байж хамтын ажиллагаагаа эхлүүллээ. Цаашид тэднээс цөмийн реакторыг нь худалдаж авах болно. Харин уранаа боловсруулж, цөмийн түлш бэлтгэх технологи зааж өгснийх нь хариуд манайхан юу амласан бол?

**Цөмийн хаягдлыг нь далд оруулж өгөхөөр амлав уу?**